

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2024 оны 03 сарын 15 өдөр

№ R-2024-20

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит  
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.4 дэх хэсэг болон 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ")-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.1 дэх хэсэг, мөн ХасБанк ("Банк")-ны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2024 оны 3 дугаар сарын 12-15-ны өдрийн хооронд хийсэн цахим санал хураалтаар гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

## ТЭМДЭГЛЭХ нь:

- ТУЗ нь Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулах үүрэгтэй болохыг; мөн
- ТУЗ нь дараах шийдвэрийг батлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

- Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 9:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпийн гудамж -19 хаягт байрлах Шангри-Ла зочид буудлын Их танхимд зарлан хуралдуулсугай.
- Хурлыг танхим болон цахим байдлаар хосолсон хэлбэрээр зохион байгуулсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Банкны ТУЗ-ийн дарга Санжай Гүптаг зарласугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавыг томилсугай. Тус комиссын гишүүдийг холбогдох дотоод журмын дагуу томилохыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай мэдэгдлийг 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн дотор СЗХ болон Монголын Хөрөнгийн Бирж ("МХБ")-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай зар мэдээг МХБ-ийн цахим хуудас, өдөр тутмын сонин, Банкны албан ёсны веб сайт ([www.xacbank.mn](http://www.xacbank.mn)), сошиал орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, зарын давталтыг тийнхүү нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх зарласан хэлбэрээр дахин нэг удаа нийтэд мэдээлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр байхаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, хурлын танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 4 дүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсуудыг 5 болон 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдэд саналыг 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 16:00 цаг хүртэл хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан, эсхүл Банкны нийт салбар, тооцооны төвөөр дамжуулан авах боломжийг бүрдүүлэн ажиллахыг Зохион байгуулах комисст даалгасугай. Саналаа цахимаар өгөхөөр төлөвлөж буй хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хурал эхлэх хүртэл буюу 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 9:00 цаг хүртэл хугацаанд өгөх боломжтой болохыг дурдсугай.
11. Хувьцаа эзэмшигчдээс урьдчилан цаасаар болон цахимаар өгсөн саналыг хувьцаа эзэмшигчдийн хурал дээр өгсөн саналтай нэгтгэн, тооллогын дүнд оруулан тооцохыг Тооллогын комисст даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэр, бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд МХБ, СЗХ-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ